



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/205

Батширээт сум

Асран хамгаалагч, харгалзан дэмжигч
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дах заалт, 67 дугаар зүйлийн 67.1.1 дэх заалт, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэргүйн Мөнхнаран нь өөрийн хүүхдүүд болох М.Халиун, М.Хосбаяр нарыг 2 жилийн хугацаанд анхаарал халамж тавихаа больсон учир М.Халиун, М.Хосбаяр нарын асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр Н.Мөнхнарангийн ээж Т. Үржинхандыг тогтоосугай.
2. Холбогдох бичиг баримтын бүрдэл, хувийн хэргийг хөтлөн ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан (Д.Нямсүрэн)-д даалгасугай.
3. Гэр бүлийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийг баримталж М.Халиун, М.Хосбаяр нарыг асран хамгаалж, харгалзан дэмжихийг (Т.Үржинханд)-д даалгасугай.
4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Норовлин багийн засаг дарга (Б.Бадамгарав), Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан (Д.Нямсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501405